



ТӨВ АЙМАГ
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/97

Бүрэн сум

Газар өмчилсөн захирамжийн
бүртгэлд залруулга оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалт, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар өмчилсөн иргэн Сэрээхүүгийн Наранчимэг (НР72091160) 2015 оны 11 дүгээр сарын 25-ны А/414 дүгээр захирамжийн бүртгэлд иргэний регистрийн дугаар буруу бичигдсэн тул иргэний мэдээллийг залруулан Сэрээхүүгийн Наранчимэг /НР72091169/ захирамжийг залруулан хавсралтаар баталсугай.

2.Газар өмчлөгч иргэнд Даалгах нь:

2.1.Өмчилсөн газрын бүртгэлд залруулгыг зөв болгон оруулан газрын кадастрын мэдээллийн санд баталгаажуулах.

2.2.Газрыг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээжүүлэх.

2.3.Газрын төлөв байдал, чанарыг доройтуулахгүй байх

3.Газрын даамал /Б.Бямбасүрэн/-д дараах ажлыг үүрэг болгох нь:

3.1.Өмчилсөн газрын бүртгэлд залруулгыг оруулан мэдээллийг кадастрын мэдээллийн санд шинэчлэн баталгаажуулах.

3.2.Газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллах.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2015 оны 11 дүгээр сарын 25-ны А/414 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Т.ТҮВШИНБАТ

410500255